



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2025/066/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Даланзадгад хот

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Одончимэг

Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.25 № 130
танай _____-ны № _____-т

Г ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БҮСИЙН Г
ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ Г
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ Г
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Г
Б.ОЮУНЧИМЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хамтын гэрээг бүртгүүлж хүчин төгөлдөр болгоогүй, их хэмжээний өр төлбөр үүсгэсэн, тооллогоор эргэлтийн хөрөнгө дутагдсан, гэм буруутай этгээдээс төсвийн хохирлыг барагдуулаагүй, бараа, ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагаа зарлаагүй, шууд худалдан авалт хийсэн зэрэг нийт 3,424,418.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 32.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасантай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд 6,826,514.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн ба үүний 99.8 хувийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

F:\2 Бичиг хэрэг\2025он\СТА\Н.Дүгнэлт\Төсөл Шорх 4673020336

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 13,178,348.4 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 241,863.4 мянга, аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 3,554,129.0 мянган төгрөгийн санхүүжилт авч өөрийн үйл ажиллагааны орлогоор 890,261.1 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны А/451 дугаар захирамжийн дагуу албан хаагчдад үндсэн цалингийн 25 хувиар тооцож орон нутгийн нэмэгдэл сар бүр олгосон байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,548,964,851.86	1,399,697,643.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	253,922,320.28	240,437,035.42
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	253,922,320.28	240,437,035.42
3121	Төгрөг	253,922,320.28	238,172,341.07
31211	Төрийн сангийн харилцах	253,921,940.28	238,171,961.07
31213	Арилжааны банк дахь харилцах	380	380
3122	Гадаад валют		2,264,694.35
31221	Төрийн сангийн харилцах		2,264,694.35
33	АВЛАГА	3,638,876.00	154,198,435.86
333	Татаас, санхүүжилтийн авлага	3,638,876.00	36,341,359.35
335	Бусад авлага		117,857,076.51
3351	Байгууллагаас авах авлага		26,060,682.51
3352	Хувь хүмүүсээс авах авлага		91,796,394.00
34	УРЬДЧИЛГАА		10,967,741.00
346	Урьдчилж гарсан зардал		10,967,741.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,291,403,655.58	994,094,431.22
351	Түүхий эд материал	948,447,382.03	643,073,280.27
3511	Тусгай зориулалттай материал	8,307,612.47	10,977,480.83
3513	Эм боох материал	940,139,769.56	632,095,799.44
354	Хангамжийн материал	342,956,273.55	351,021,150.95
3541	Бичиг хэргийн материал	21,588,342.39	29,697,979.95
3542	Аж ахуйн материал	161,007,945.00	142,961,395.00
3543	Сэлбэг хэрэгсэл	8,514,099.00	7,735,099.00
3544	Түлш, шатах тослох материал	6,423,930.00	
3545	Барилгын засварын материал	14,296,999.99	13,051,999.99
3546	Хүнсний материал	39,803,280.00	42,413,239.00
3547	Бусад хангамжийн материал	91,321,677.17	115,161,438.01
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	21,268,628,442.70	27,297,147,358.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	21,268,628,442.70	27,297,147,358.73
392	Биет хөрөнгө	20,576,587,657.76	26,605,959,654.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	15,311,591,146.24	16,361,939,498.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4,015,688,311.73	-4,112,616,389.93
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,185,439,498.00	1,648,788,303.21
39204	Хуримтлагдсан элэгдэл	-615,600,412.52	-490,992,433.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	21,690,464,107.50	18,919,183,032.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,512,440,308.31	-6,539,023,676.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,099,799,236.76	1,047,292,566.41
39208	Хуримтлагдсан элэгдэл	-566,977,298.18	-228,611,245.40
393	Биет бус хөрөнгө	692,040,784.94	691,187,703.77
39301	Програм хангамж	59,477,800.00	32,139,000.00

39302	Хуримтлагдсан элэгдэл	-36,137,015.06	-9,651,296.23
39303	Бусад биет бус хөрөнгө	668,700,000.00	668,700,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	22,817,593,294.56	28,696,845,002.23
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,075,046,740.81	4,413,410,411.34
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,075,046,740.81	4,413,410,411.34
413	Өглөг	3,075,046,740.81	4,413,410,411.34
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	777,283,962.58	1,250,698,907.14
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,247,379,277.30	3,110,816,942.27
4136	Бусад өглөг	50,383,500.93	51,894,561.93
41361	Байгууллагад төлөх өглөг	50,383,500.93	50,383,500.93
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		1,511,061.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	19,742,546,553.75	24,283,434,590.89
51	Засгийн газрын хувь оролцоо	19,742,546,553.75	24,283,434,590.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,053,346,050.75	5,053,346,050.75
51101	Өмч: - төрийн	5,053,346,050.75	5,053,346,050.75
512	Хуримтлагдсан үр дүн	12,456,148,725.35	16,997,036,762.49
5121	Өмнөх үеийн үр дүн	12,456,148,725.35	12,456,148,725.35
5122	Тайлант үеийн үр дүн		4,540,888,037.14
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,233,051,777.65	2,233,051,777.65
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	22,817,593,294.56	28,696,845,002.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	19,097,467,863.13	24,834,945,179.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,503,394,784.13	7,827,901,832.09
120	Нийтлэг татварын бус орлого	9,503,394,784.13	7,827,901,832.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,572,084,233.59	4,760,835,568.44
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	846,914,347.59	890,261,062.44
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,725,169,886.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		3,870,574,506.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	5,365,761,789.80	2,945,574,060.19
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,565,548,760.74	121,492,203.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,594,073,079.00	17,007,043,347.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,795,992,413.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,554,129,003.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		241,863,410.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,594,073,079.00	13,211,050,934.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,594,073,079.00	13,211,050,934.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	18,110,979,665.79	20,294,057,141.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,110,979,665.79	20,294,057,141.93

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,153,151,241.79	19,812,318,422.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,898,017,773.33	11,296,020,395.95
210101	Үндсэн цалин	3,532,406,056.06	4,961,489,799.58
210102	Нэмэгдэл	2,737,503,426.66	4,903,588,309.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	257,053,000.00	276,594,000.00
210104	Урамшуулал	367,359,576.61	1,151,048,287.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,695,714.00	3,300,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	937,500,640.42	1,399,593,152.69
210201	Тэтгэврийн даатгал	663,636,848.06	942,888,315.53
210202	Тэтгэмжийн даатгал	87,016,427.96	114,642,578.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	55,314,901.77	84,213,890.18
210204	Ажилгүйдлийн даатгал	11,940,686.45	61,153,439.82
210205	Эрүүл мэндийн даатгал	119,591,776.18	196,694,929.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	896,430,587.87	932,484,341.39
210301	Гэрэл, цахилгаан	216,798,054.05	234,957,830.32
210302	Түлш, халаалт	454,045,412.82	442,805,410.07
210303	Цэвэр, бохир ус	225,587,121.00	254,721,101.00
2104	Хангамж, бараа материалын зардал	410,838,711.76	439,387,387.60
210401	Бичиг хэрэг	45,536,477.33	72,455,862.44
210402	Тээвэр, шатахуун	165,750,600.00	148,068,630.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,817,709.92	22,980,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	125,000.00	80,319,996.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	89,476,723.97	115,562,899.16
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	80,928,200.54	
210408	Бараа материал актальсны зардал	204,000.00	
2105	Нормативд зардал	5,343,804,195.81	4,605,662,036.88
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,933,769,470.86	4,312,330,812.88
210502	Хоол, хүнс	398,246,853.34	293,331,224.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,787,871.61	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	127,018,137.80	213,612,466.80
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,719,550.00	7,526,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		2,999,800.00
210604	Урсгал засвар	105,298,587.80	203,086,666.80
2107	Томилолт, зочны зардал	28,982,000.00	23,535,100.00
210702	Дотоод албан томилолт	28,982,000.00	23,535,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	138,107,218.33	104,027,891.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	119,924,579.00	97,968,801.38
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	603,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,364,525.00	862,040.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,148,272.83	2,400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	363,000.00	466,600.00
210807	Газрын төлбөр	5,379,600.00	1,413,750.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,927,241.50	313,400.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,372,451,976.47	797,995,650.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,009,108.52	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,343,442,867.95	797,995,650.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	957,828,424.00	481,738,719.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	957,828,424.00	481,738,719.10
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		200,880,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	957,828,424.00	280,858,719.10
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	986,488,197.34	4,540,888,037.16
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		0.02
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө		0.02
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-0.02
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	986,488,197.34	4,540,888,037.14

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	12,162,518,436.59	17,864,601,926.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,572,084,233.59	890,261,062.44
120	Нийтлэг татварын бус орлого	2,572,084,233.59	890,261,062.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,572,084,233.59	890,261,062.44
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	846,914,347.59	890,261,062.44
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,725,169,886.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,590,434,203.00	16,974,340,863.65
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,795,992,413.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,554,129,003.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		241,863,410.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,590,434,203.00	13,178,348,450.65
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,590,434,203.00	13,178,348,450.65
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	11,897,665,006.51	17,867,721,210.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,897,665,006.51	17,867,721,210.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,846,379,861.51	17,408,379,734.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,588,847,181.00	11,003,791,837.69
210101	Үндсэн цалин	3,226,654,420.86	4,186,924,462.03
210102	Нэмэгдэл	2,736,736,985.26	5,576,802,682.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	256,785,833.72	262,859,014.28
210104	Урамшуулал	365,542,622.67	974,524,378.47
210105	Гэрээт ажлын хөлс	3,127,318.49	2,681,300.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	589,878,646.00	1,332,542,000.00
210201	Тэтгэврийн даатгал	415,549,000.00	958,263,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	53,171,300.00	101,069,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	33,810,700.00	50,534,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,452,600.00	50,534,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	78,895,046.00	172,139,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	340,048,153.14	1,597,146,005.65
210301	Гэрэл, цахилгаан	72,599,314.53	379,434,621.87
210302	Түлш, халаалт	177,199,007.61	775,716,819.78
210303	Цэвэр, бохир ус	90,249,831.00	441,994,564.00
2104	Хангамж, бараа материалын зардал	333,539,064.92	385,540,000.00
210401	Бичиг хэрэг	21,033,065.00	50,001,900.00
210402	Тээвэр, шатахуун	153,659,000.00	136,250,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,599,999.92	25,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,690,600.00	24,860,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	120,556,400.00	149,428,100.00
2105	Нормативт зардал	2,619,950,184.62	2,803,304,135.13
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,097,411,870.62	2,552,360,483.13
210502	Хоол, хүнс	421,886,064.00	230,752,352.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,652,250.00	20,191,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	158,141,935.00	137,008,870.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,150,000.00	7,526,000.00
210602	Тавилга	2,062,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		3,000,000.00
210604	Урсгал засвар	150,929,935.00	126,482,870.00
2107	Томилолт, зочны зардал	28,982,000.00	23,535,100.00
210702	Дотоод албан томилолт	28,982,000.00	23,535,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	162,224,876.83	125,511,786.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	131,137,065.00	112,773,196.38
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	603,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,364,525.00	862,040.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,148,272.83	2,400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	363,000.00	466,600.00
210807	Газрын төлбөр	5,389,014.00	1,413,750.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	16,823,000.00	6,992,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,767,820.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,767,820.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,051,285,145.00	459,341,476.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,051,285,145.00	459,341,476.10
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		200,880,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,051,285,145.00	258,461,476.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	264,853,430.08	-3,119,284.86

	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	91,067,700.00	10,366,000.00
	Дотоод эх үүсвэрээр	91,067,700.00	10,366,000.00
223001	Бусад хөрөнгө	91,067,700.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		10,366,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-91,067,700.00	-10,366,000.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	173,785,730.08	-13,485,284.86
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		253,922,320.28
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		240,437,035.42

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,053,346,050.75	2,233,051,777.65	12,456,148,725.35	19,742,546,553.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,053,346,050.75	2,233,051,777.65	12,521,591,509.28	19,807,989,337.68
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			4,540,888,037.14	4,540,888,037.14
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,053,346,050.75	2,233,051,777.65	16,997,036,762.49	24,283,434,590.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,988,658,900.00	17,878,087,210.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,056,753,600.00	17,878,087,210.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,958,943,800.00	17,418,745,734.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,900,914,100.00	11,003,791,837.69
210101	Үндсэн цалин	5,607,878,100.00	4,186,924,462.03
210102	Нэмэгдэл	3,579,696,700.00	5,576,802,682.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	460,147,800.00	262,859,014.28
210104	Урамшуулал	1,253,191,500.00	974,524,378.47
210105	Гэрээт ажлын хөлс		2,681,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,263,370,900.00	1,332,542,000.00
210201	Тэтгэврийн даатгал	859,092,200.00	958,263,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	101,069,700.00	101,069,700.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	50,534,800.00	50,534,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	50,534,800.00	50,534,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	202,139,400.00	172,139,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,838,616,800.00	1,597,146,005.65
210301	Гэрэл, цахилгаан	488,616,800.00	379,434,621.87
210302	Түлш, халаалт	850,000,000.00	775,716,819.78
210303	Цэвэр, бохир ус	500,000,000.00	441,994,564.00
2104	Хангамж, бараа материалын зардал	362,532,300.00	385,540,000.00
210401	Бичиг хэрэг	54,000,000.00	50,001,900.00
210402	Тээвэр, шатахуун	101,500,000.00	136,250,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000,000.00	25,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,000,000.00	24,860,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	147,032,300.00	149,428,100.00
2105	Нормативт зардал	2,382,066,300.00	2,803,304,135.13
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,128,692,700.00	2,552,360,483.13
210502	Хоол, хүнс	232,532,300.00	230,752,352.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,841,300.00	20,191,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,000,000.00	147,374,870.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,000,000.00	17,892,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	38,000,000.00	126,482,870.00
2107	Томилолт, зочны зардал	23,810,000.00	23,535,100.00
210702	Дотоод албан томилолт	23,810,000.00	23,535,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,538,700.00	125,511,786.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,000,000.00	112,773,196.38
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	603,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	862,040.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,400,000.00	2,400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	480,000.00	466,600.00
210807	Газрын төлбөр	3,158,700.00	1,413,750.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	12,000,000.00	6,992,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,097,809,800.00	459,341,476.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,097,809,800.00	459,341,476.10
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	223,680,000.00	200,880,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	874,129,800.00	258,461,476.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,988,658,900.00	17,864,601,926.09
	Дотоод эх үүсвэрээр		3,795,992,413.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,097,414,000.00	3,795,992,413.00
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,873,994,900.00	3,554,129,003.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	223,419,100.00	241,863,410.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,184,251,500.00	13,178,348,450.65
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,184,251,500.00	13,178,348,450.65
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	706,993,400.00	890,261,062.44
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	706,993,400.00	890,261,062.44
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		253,922,320.28
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		240,437,035.42
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,988,658,900.00	17,878,087,210.95

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,087,949.9 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,087,949.9 мянган төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Жилийн эцсийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт тайлангийн тодруулга бэлтгэж ирүүлээгүй,
- Санхүүгийн байдлын тайлан болон өглөгийн тайланд эмийн өглөгийг 431,299,1 мянга, бусад зардлын өглөгийг 267,281.8 мянган төгрөгөөр илүү, ажиллагсадтай холбоотой өглөгийг 293,516.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн
- Санхүүгийн үр дүнгийн тайланд цалин, шимтгэлийн зардлыг 84,885.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн
- БОЭТ-өөс иргэн Н.Гарьдхүүтэй Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээг 2024 оны 7 сараас 2025 оны 7 сар дуустал хугацаанд байгуулж, ажлын хөлсөнд урьдчилан олгосон 10,967.7 мянган төгрөгийг урьдчилж төлсөн зардалд тайлагнаагүй,

Аудитаар нийт 3,096,737.4 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс 3,004,941.0 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 91,796.4 мянган төгрөгийн зөрчилд удирдлага зохион байгуулалт, дотоод хяналт сайжруулахтай холбоотой 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

5.2 Албан шаардлага

1. БОЭТ-ийн удирдлагын баг, ажиллагсдын үйлдвэрчний эвлэлийн хороо хооронд 2023 оны 03 сарын 22-ны өдрөөс 2025 оны 03 сарын 22-нийг хүртэлх хугацаанд хамтын гэрээг байгуулсан боловч Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгүүлж хүчин төгөлдөр болгоогүй илүү цагийн хөлсийг 1.9 дахин нэмэгдүүлэн олгосон, бусад цалин хөлстэй холбоотой зохицуулалтаас үүдэн ажиллагсадтай холбогдсон 1,250,698.9 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэхэд хүргэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 "Хамтын гэрээ, аймаг, сум, нийслэл, дүүргийн хамтын хэлэлцээрийг харьяа нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн байгууллагад, салбар, салбар дундын хамтын хэлэлцээрийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэхээр ажлын 10 өдрийн дотор ажилтны төлөөлөгч, эсхүл ажил олгогчийн төлөөлөгч хүргүүлнэ", 32.2 "Бүртгэх эрх бүхий байгууллага хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг ажлын таван өдрийн дотор хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянаж, нийцэж байвал тухайн хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг бүртгэж, мэдээллийн санд оруулна. Ийнхүү бүртгэснээр уг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр хүчин төгөлдөр болно"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

2. Тайлант онд 230,573.4 мянган төгрөгийн хоол хүнсний материал, 2,552,360.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 149,428.1 мянган төгрөгийн аж ахуй, цэвэрлэгээний материалыг сонгон шалгаруулалт хийгээгүй, нээлттэй тендер зарлаагүй шууд худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", 32 дугаар зүйлийн 32.1-т "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3. Захирлын 2024 оны А/111 дүгээр тушаалаар байгуулагдсан хөрөнгийн тооллогын комиссын тооллогоор 10 нэр төрлийн 7,735.1 мянган төгрөгийн үнэ бүхий сэлбэг хэрэгсэл, 51 нэр төрлийн 17,678.0 мянган төгрөгийн үнэ бүхий аж ахуйн материал, 8,325.0 мянган төгрөгийн үнэ бүхий хулдаас, 120 нэр төрлийн 38,840.9 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэл тус тус дутагдсанд холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4 "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"-д заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Удирдлага зохион байгуулалт, дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:1 БОЭТ-ийн гүйцэтгэх захирлыг Эрүүл мэндийн сайдын 2024 оны Б/22 дугаар тушаалаар томилсон бөгөөд эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлөөс томилоогүй, ТУЗ байгуулаагүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-д "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15.1-д заасан шалгуурын дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн сонгож ТУЗ байгуулж холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

Илрүүлэлт: 2 Тус төв нь 154,198.4 мянган төгрөгийн авлага, 4,413,410.4 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэн ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, даатгалын санхүүжилтийг үзүүлсэн эмчилгээ, үйлчилгээгээр бүрэн авах, нэхэмжлэлийн шаардлага хангаагүй, зөрчил дутагдлыг арилгах, төсвийг зохистой удирдаж, өр, авлагыг бууруулж ажиллах

Илрүүлэлт:3 Тус байгууллагын албан хаагч Д.Даваасамбуу, А.Болдмаа нарт шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг нөхөн олгож, 91,796.4 мянган төгрөгийг байгууллагаас төлж, улмаар гэм буруутай этгээдээс буцааж төлүүлээгүй, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2 "Энэ хуулийн 103.1-д заасан гэм

буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна"-д заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2-д заасныг хэрэгжүүлж, дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгжид хандаж төрд учирсан хохирлыг барагдуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
БОЭТ-ийн удирдлагын баг, ажиллагсдын үйлдвэрчний эвлэлийн хороо хооронд 2023 оны 03 сарын 22-ны өдрөөс 2025 оны 03 сарын 22-нийг хүртэлх хугацаанд хамтын гэрээг байгуулсан боловч Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгүүлж хүчин төгөлдөр болгоогүй илүү цагийн хөлсийг 1.9 дахин нэмэгдүүлэн олгосон, бусад цалин хөлстэй холбоотой зохицуулалтаас үүдэн ажиллагсадтай холбогдсон 1,250,698.9 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэхэд хүргэсэн байна.	1	0			1	0						
Тайлант онд 230,573.4 мянган төгрөгийн хоол хүнсний материал, 2,552,360.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 149,428.1 мянган төгрөгийн аж ахуй, цэвэрлэгээний материалыг сонгон шалгаруулалт хийгээгүй, нээлттэй тендер зарлаагүй шууд худалдан авсан байна.	1	2,932,362.0			1	2,932,362.0						
Захирлын 2024 оны А/111 дүгээр тушаалаар байгуулагдсан хөрөнгийн тооллогын комиссын тооллогоор 10 нэр төрлийн 7,735.1 мянган төгрөгийн үнэ бүхий сэлбэг хэрэгсэл, 51 нэр төрлийн 17,678.0 мянган төгрөгийн үнэ бүхий аж ахуйн материал, 8,325.0 мянган төгрөгийн үнэ бүхий хулдаас, 120 нэр төрлийн 38,840.9 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэл тус тус дутагдсанд холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.	1	72,579.0			1	72,579.0						

БОЭТ-ийн гүйцэтгэх захирлыг Эрүүл мэндийн сайдын 2024 оны Б/22 дугаар тушаалаар томилсон бөгөөд эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлөөс томилоогүй, ТУЗ байгуулаагүй байна.	1	0					1	0				
Тус төв нь 154,198.4 мянган төгрөгийн авлага, 4,413,410.4 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэн ажилласан байна	1	0					1	0				
Тус байгууллагын албан хаагч Д.Даваасамбуу, А.Болдмаа нарт шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг нөхөн олгож, 91,796.4 мянган төгрөгийг байгууллагаас төлж, улмаар гэм буруутай этгээдээс буцааж төлүүлээгүй, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.	1	91,796.4					1	91,796.4				
Дүн	6	3,096,737.4			3	3,004,941.0	3	91,796.4				

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Жилийн эцсийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт тайлангийн тодруулга бэлтгэж ирүүлээгүй	1	0	1	0			1	0				
Санхүүгийн байдлын тайлан болон өглөгийн тайланд эмийн өглөгийг 431,299.1 мянга, бусад зардлын өглөгийг 267,281.8 мянган төгрөгөөр илүү, ажиллагсадтай холбоотой өглөгийг 293,516.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн	1	992,096.9			1	992,096.9	1	992,096.9				
Санхүүгийн үр дүнгийн тайланд цалин, шимтгэлийн зардлыг 84,885.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн	1	84,885.2			1	84,885.2	1	84,885.2				
БОЭТ-өөс иргэн Н.Гарьдхүүтэй Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээг 2024 оны 7 сараас 2025 оны 7 сар дуустал хугацаанд байгуулж, ажлын хөлсөнд урьдчилан олгосон 10,967.7 мянган төгрөгийг урьдчилж төлсөн зардалд тайлагнаагүй	1	10,967.7	1	10,967.7			1	10,967.7				
Дүн	4	1,087,949.8	2	10,967.7	2	1,076,982.1	4	1,087,949.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тухайн жилийн баталсан төсөв, дараа жилийн төсвийн төсөөлөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан мэдээлээгүй, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийг шалтгааныг тайлбарлаагүй, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг тус тус мэдээлээгүй, хөрөнгө зарцуулсан 327,681.3 мянган төгрөгийн 11 шийдвэрийг хугацаандаа мэдээлээгүй байна.	1	327,681.3					1	327,681.3
ДҮН	1	327,681.3						327,681.3